

Хэсэг 20

Халх Монгол дахь бурханы шашны сүм хийд, хуврагийн чуулганы тогтолцоо

Пүрэвжавын Лхам

Редакторын үг: Энэхүү нарийвчилсан, чамбай илтгэлдээ П. Лхам Монголын бурханы шашны сүм хийдийн нийгэм, улс төр, эдийн засгийн зохион байгуулалтыг бидэнд танилцуулж байна. Тэрбээр эх материалыг дэлгэрэнгүй судалснаар, сүм хийд, лам нарын өсөлт, сүм хийдийн зохион байгуулалтын бүтэц, эдийн засгийн үйл ажиллагаа, засаг захиргааны зохион байгуулалтын хүчин зүйлсийг тодруулжээ.

Судлаач П. Лхам Монголын сүм хийдийн Төвдтэй зарим талаар төстэй, мөн ялгаатай түүхийн талаарх бидний ойлголтыг ихэд тэлж өгч байна. Энэхүү баялаг суурь судалгаанаасаа чадварлаг судлаач П.Лхам, цаашид Монголын түүхийн илүү өргөн хүрээтэй үзэл хандлагыг хөгжүүлэх буй заа. Бидний энэхүү номонд П.Лхамын танилцуулсан шашны зохион байгуулалт ба Др. Дэвид Снийтийн дэвшүүлсэн Монголын нийгэм, улс төрийн зохион байгуулалтын түүхэн бүрэлдэл, ижилслийн уян хатан зохион байгуулалтын бүтцийн хооронд гайхалтай адил төстэй ба ялгаатай талууд байгааг бид харж болохоор байна.

Өмнөх үг

Монголын Эзэнт гүрэн өөрийн захиргаан дахь ард түмний олон шашинд хүлээцтэй хандаж байсан гайхалтай түүхтэй билээ. Монголын Эзэнт гүрний үед Диян (Зэн), болон Хятадын бурханы шашинтнууд Монголчуудад зүтгэж байсан¹ сонирхолтой баримт байдаг. Харин Мөнх хааны үеэс Төвдийн бурханы шашинтай холбоо тогтоосон боловч Монголын эзэнт

¹ Этвуд 2004: 48

гүрэн доройтоход бурханы шашин Монголчуудын дундах байр сууриа алдсан байна. Хоёрдахь удаагаа Монголчууд XVI зуунд бурханы шашныг хүлээн авсан ба энэ удаагийн дэлгэрэлт нь Монголын эзэнт гүрний үеийн ордны хүрээн дэхь өглөгийн эзэн, улсын багшийн харилцаанд төвлөсөн, сүм хийд өргөн тогтолцоо үгүй байдлаас ялгаатай байв. Сүм хийдийн хүчирхэг тогтолцоо, санхагийн хөгжил, бурханы шашны өндөр боловсрол, мэдлэг ухааны хуримтлал, бүтээл туурвил, энэхүү хоёрдахь дэлгэрэлтийг тодорхойлдог. Энэхүү дэлгэрэлт, түүний хөгжил нь улс төрийн бие даасан улс, бүлгүүдийн сонирхол, шашин дэлгэрүүлэх үйл ажиллагаа, хожим нь Манж Чин гүрний засаг захиргааны тогтолцооны онцлогоор нөхцөлдсөн гэж хэлж болох юм. XIX зууны төгсгөл үед Монгол нь мянга гаруй бурханы шашны сүм, хийд, хурлын газар бүхий сүм хийдийн хүчирхэг тогтолцоог бий болгосон байв. Энэхүү илтгэлд XVI-XIX зуунд Халх Монголд сүм хийд хэрхэн байгуулагдаж хөгжснийг тоймлон өгүүлэх болно.

Монголын Юан гүрэн доройтон унаснаас хойш Монголчууд улс төрийн нэгдмэл байдлаа алдаж бие даасан улсууд төрөөс тусгаарлах эрмэлзэл тэмцэл хүчтэй болсон байна. Энэ үед Төвдийн бурханы шашны урсгал, төлөөлөгчидтэй холбоо тогтоох нь улсуудын хувьд өөрсдийн эрх хүчийг баталгаажуулах гол арга зам болж байв. Энэхүү арга зам нь Хубилай хаан, Пагва ламын өглөгийн эзэн, багш, шавийн харилцаанаас эхтэй бөгөөд энэ үед бие биенийхээ эрх хүчийг баталгаажуулах сонгодог загвар болон хэрэглэгдсэн юм. Язгууртан ноёд өвөр хоорондоо өрсөлдөн Төвдийн бурханы шашны урсгалын төлөөлөгчидтэй холбоо тогтоож байсан нь XVI-XVII зууны Монголын түүхийн гол онцлог болж байв. Улмаар бурханы шашин Түмэд, Халх, Цахар, Ойрад, Өмнөд бүх Монголчуудын дунд дэлгэрч эхэлсэн. Элвэрскогийн үзсэнээр "...Төвдийн бурханы шашин, түүний

урсгалууд нь улс төрийн нэгдлээ алдсан олон Монгол бүлгүүдэд (улс) тусгаар байдлаа баталгаажуулах нөхцлийг өгсөн ... Улс аймгийн удирдагчид Даян хааны төрийн суурь үндсэн дээр тусгаар байдлаа батлах боломжгүй гэдгийг ойлгосон байв.”¹

Энэхүү дэлгэрэлтийн түрүү үеийн нөхцөл байдал 1691 онд Халх Монгол Манжийн засаг захиргаанд орох хүртэл үргэлжилсэн. Манж Чин гүрэн Халх Монголыг 36 хошуунд хуваан зохион байгуулав. Хошууд нэмэгдэн байгуулагдсаар XIX зууны төгсгөлд 86-д хүрчээ. Өөрөө өөрийн дотоод аж ахуй, зохион байгуулалтыг хариуцан оршиж байсан хошуудын тогтолцоо Халх Монголд бурханы шашин дэлгэрэх дараагийн шатыг зассан байна. Бие даасан *хошуу нийгэм* болон оршиж байсан тэд өөр өөрийн сүм хийдийг байгуулж тусдаа коммунити гэдгээ тэмдэглэж бас бүтээж байв. Хошуудын сүм хийд өсөн нэмэгдэх явцад Чин гүрнээс ивээн тэтгэсэн сүм хийд ч бас зэрэгцэн байгуулагдсан ба тэдгээрийн тоо цөөн ч нийт Монголчуудын дунд танигдсан, нэртэй газрууд болж чадсан байна. Анхдугаар Богд Өндөр гэгээний үеэс эх сууриа тавьсан Их шавийн сүм хийдүүд нь Халх Монголын сүм хийдийн тогтолцооны гол цөм болон хөгжсөн ба мөн XIX зууны эхнээс байгуулагдаж богино хугацаанд шашин, соёл, нийгмийн томоохон төвүүд болсон бүс нутгийн сүм хийдүүд бий болсон байв. Ийнхүү хоёрдахь дэлгэрэлтийн хөгжил, хэлбэрийг илтгэх түрүү үеийн тахил, бүтээлийн, хошууны, их шавийн, бүс нутгийн хэмээх дөрвөн бүлэг сүм хийд, тэдгээрийн засаг захиргаа, аж ахуйн зохион байгуулалт, сүм хийдийн тогтолцоонд учирч байсан зарим бэрхшээлийг дор авч үзэх болно.

¹ Элвэрског 2009: 21

Тахил, бүтээлийн сүм хийдүүдийн ба түрүү үе

Монголын бурханы шашны хоёрдахь дэлгэрэлтийн анхны томоохон сүм хийд Эрдэнэ зууг Халх Монголын хан Автай 1587 байгуулснаар Монголын бурханы шашны хөгжлийн нэгэн хүчирхэг үеийн эхлэл болдог. Энэ үеийн томоохон сүм хийдүүд Халхын томоохон язгууртан ноёдын санаачилга, ивээлээр байгуулагдаж байсан ба мөн энэ хүрээнээс анхны томоохон хутагт хувилгаад тодорч байв. Бидэнд мэдэгдэж буй баримт, сурвалжаас үзэхэд анхны тахилын сүм, суваргыг Халхын ноён Цогт тайж 1601-1617 онуудад (хэд хэдэн тахилын сүм, суварга) бүтээж босгосон бололтой. Халхын анхдугаар Богд Өндөр гэгээн Рибогэжэйлин (хэдийгээр устгагдсан боловч өнөөгийн Гандантэгчэнлин хийдийн эх гэж үздэг), Ганданшадүвлин (Шанхын хийд) болон Төвхөн сүм хийдүүдийг байгуулав. Эдгээр нь гол төлөв бясалгал, бүтээлийн сүм хийдийн шинж чанартай байсан ба зарим нь устаж үгүй болсон ч залгамж хийдүүд нь байгуулагдаж сүм хийдийн тогтолцооны эх, цөм болсон. Өндөр Гэгээний ураг садан, үеэл Халхын Зая Бандида болон Ламын Гэгээн нар нь Халхын анхны томоохон хутагтууд байсан ба тэд өөрсдийн сүм хийдээ 1650, 1677 онуудад байгуулав. Ойрадын Галдан бошготын довтолгооны үеэр энэхүү эхэн үеийн сүм хийдийн нэлээдгүй нь сүйтгэгдэж дахин сэргэж чадаагүй юм. 1587-1686 оны үед байгуулагдсан Халх Монголын бурханы шашны хоёрдахь дэлгэрэлтийн үеийн эхэн үеийн сүм хийдүүдийн байгуулагдсан он, санаачлан үндэслэгчдийг дор харуулъя.

Хоёрдахь дэлгэрэлтийн эхэн үеийн сүм хийдүүдийн нэр	Байгуулагдсан он	Санаачлагч, үндэслэгч	Төвдийн аль урсгал, дэг сургуулийнх болох
Эрдэнэ зуу	1587	Түшээт хан Автай	Сахьяа
Наран	1607		
Заяын хүрээ	1616	Анхдугаар Зая Бандид	Гэлүгва, Сэра хийд

Сэтгэшгүй чандмань 6 сүм	1601-1617	Цогт тайж	
Гандандондовлин хийд	1632		
Ганданшадүвлин хийд (Баруун хүрээ буюу Шанхын хийд)	1647	Анхдугаар Богд Өндөр гэгээн	Гэлүгва, Бэрэйвэн хийд
Гонгандан дэдлин хийд (Ламын гэгээний хүрээ)	1650	Анхдугаар дүрийн Ламын гэгээн	Гэлүгва, Дашлхүмбо хийд
Рибогэжэйлин (Сарьдагийн хийд, мөн Гандантэгчинлин хийдийн эх)	1654	Анхдугаар Богд Өндөр гэгээн	Гэлүгва, Бэрэйвэн хийд ба Чойнхорлин дэг
Дэвсэнбулагийн хийд	1659		
Гүндгаравлин хийд	1660		Гэлүгва, Дашлхүмбо
Гэндүнлин хийд	1686		

Галдан бошготын довтолгоон, Өндөр гэгээний Халхад эзгүй байсан зэрэг нөхцөл хоёрдахь дэлгэрэлтэнд XVIII зууны дунд үе хүртэл үргэлжилсэн зогсонги байдлыг авчирсан байна. Үлдэж хоцорсон сүм хийдүүд нь тахил, эргэл мөргөлийн үүрэгтэй, байнгын тогтмол хурал, ном, сургалтын үйл ажиллагаагүй болсон нь цөөнгүй байв. Өндөр гэгээний үндэслэн байгуулсан гэлүгва урсгалын Халх Монголын гол хийд Рибогэжэйлинг залгамжилсан хийд хүрээ энэхүү дайн самуун болон мөн бэлчээрийн шаардлагаас шалтгаалан 23 удаа нүүхэд хүрсэн байдаг. Хоёрдахь дэлгэрэлтийн үеийн ууган хийд Эрдэнэ зуу нь цаашид Халх Монгол нийт даяарын эргэл мөргөлийн гол төв болон хувирч хөгжжээ. Эрдэнэ зуу хийдийн хэрмийн 108 суваргыг XVIII-XIX зуунд Халх Монголын хошууд нэг бүрээс барьж босгосон бөгөөд энэ нь Халх Монголын нэгдлийн бэлгэдэл болдог байна. Эрдэнэ зуу хийд ууган хийдийн хувиар Халх Монголын бурханы шашны төв болон хөгжих боломжтой байсан боловч түүний үүсгэл эх дэг болон эхэн үеийн сүм хийдийн зориулалтаас шалтгаалан эргэл мөргөлийн төв, гол ариун орны чиглэл рүү хөгжсөн байна. Халхын анхдугаар Богд Жавзандамба Өндөр гэгээний

үндэслэн байгуулсан сүм хийдүүд залгамжлагдан сэргэж байгуулагдан улмаар түрүү үеийн уламжлалыг гол тээгч болж цаашдын бурханы шашны хөгжлийн голт зүрх болон хөгжсөн юм.

Хошууны сүм хийд

Халх Монголын сүм хийдийн дийлэнхи зонхи нь хошууны сүм хийд хэмээх ангилалд багтана. Хошууны засаг ноёд болон тайж нараас мөн л өөрийн эрх хүчийг илтгэх, батлах зорилготой олон сүм хийдийг байгуулжээ. Энэ нь XVI зуунд Түмэдийн Алтан хан, III Далай ламын хамтын ажиллагаа болон хожмын Халхын гурван ханы үйл ажиллагаанаас эхтэй бөгөөд Өргөх цэс¹-ийн мэдээнээс үзэхэд хошууны засаг ноён засаг залгамжлахдаа шинэ сүм, дацан, хурал үүсгэн байгуулж байсан нь түгээмэл ажиглагдана. XIX зууны эцсээр нэг хошуу дунджаар 7-15 сүм хийдтэй ба тэдгээрийн дотор 50-100 орчим лам хувраг бүхий, жилийн тогтмол хурал, жасаагүй жижиг сүм хийд олон байв. Хошууны сүм хийдийн олонхи лам хувраг мал сүрэг адгуулан гэргийтний амьдралын хэв маягаар амьдарч, гол томоохон зан үйл, ёслолдоо цугларах нь түгээмэл байжээ.

Сүм хийдийн хөрөнгө, аж ахуй нь жас хэмээх тусгай зохион байгуулалтаар зохицуулагддаг жас бүр нь аль нэгэн хурал, зан үйлийг хариуцсан түүнд зориулагдсан байдаг байв. Олон хурал, зан үйлийг хариуцсан жасуудын нэгдмэл тогтолцоо нь эдийн засгийн ямар ч эрсдлийн үед хурал, номын үйл ажиллагааг таслахгүй байх, мөн нөгөө талдаа өглөг, хандивийн үндсэн дээр шинээр хурал, ном бий болохыг хангасан тогтолцоо байв. Сүм хийдийн аж ахуй нь энэхүү жасаас гадна сан хэмээх өөр нэгэн нэгжтэй бөгөөд энэ нь аливаа эрсдлийн үед зайлшгүй шаардлагатай жасуудын үйл

¹ Өргөх цэс нь 1918 онд Богд хаант Монгол улсын үед Монгол улсын шастир арван боть зохиол бичихэд зориулж хошуудаас сүм, хийд хурлын газрыг уг, эхийг тодруулсан баримт юм. Эдгээрийг Банзрагч гуай 2000 онд эмхэтгэн Монголын хүрээ хийдийн түүх ном болгон хэвлүүлсэн болно.

ажиллагааг хангах, бүхэлдээ сүм хийдийн тасралтгүй үйл ажиллагааг хангах үүрэгтэй сан, нөөцийн зохион байгуулалт байв. Ихэнхи хошууны сүм хийд энэхүү эдийн засгийн давхар тогтолцоогүй буюу сан хэмээх нэгж нь тэр бүр байдаггүй байна. Тиймээс ч *Өргөх цэс*-ийн мэдээгээр хошууны сүм хийдүүдийн олон хурал, зан үйл зарим үед түр зогсож дахин шинээр үүсгэгддэг байсан нь харагдана.

Богд Хаант Монгол улсын үед зарим нэг хошуудын засаг ноёдоос өөрийн хошууны сүм хийдийг Богдын Их шавьд өргөх хүсэлтээ илэрхийлж байсан нь цөөнгүй тохиолддог. Энэ нь Чин улсын цалингийн тогтолцоо, өөрөө өөрийгөө хангах тогтолцоотой хошууны засаг ноёны засаглал нь эдийн засаг, зохион байгуулалтын хувьд бат суурьтай биш байсантай холбоотой гэж үзэж болно. Сүм хийдийн жасын дансны мэдээгээр хошуудын засаг ноёд сүм хийдийн жасын хамгийн идэвхитэй зээлдэгчид байдаг билээ. Хошууны сүм хийдийн хязгаарлагдмал байдалтай харьцуулахад Их Шавийн сүм хийд нь хоорондоо уялдаа бүхий олон сан, жастай тогтвортой тогтолцоо байв.

Манж Чингийн төрөөс шууд ивээн тэтгэгдэн байгуулагдсан сүм хийдийг Позднеев Чингийн эзэн хааны сүм хийд хэмээн нэрлэсэн. Тэдгээр нь үлэмж их хөрөнгө оруулалттай байсан ч голлох сүм хийд болон хөгжиж чадаагүй. Энэ нь тодорхой хангамж бүхий байсан нь сан, жасын нарийн нийлмэл тогтолцоо бий болоогүйгээс өргөжин тэлж хөгжөөгүйтэй зарим талаар холбогдоно.

Их Шавийн сүм хийд

Халх Монголын бурханы шашны тэргүүн Богд Жавзандамбын Их шавийн² сүм хийд нь гуравдахь бүлэг болно. Их шавьд хорь орчим сүм харьяалагдаж байсан ба

² Их шавь гэдэг нь Богд Жавзандамбын харьяат хамжлага ард хүмүүсийг хэлнэ.

үүнийг Эрдэнэ шанзодба хэмээх тусгай байгууллагаас захирч байв. Богдын хүчирхэг байр суурь, эдийн засгийн батгай байдал нь хошууны сүм хийдтэй харьцуулшгүй байв.

Их Шавийн харьяаны Их Хүрээн дэхь Гандантэгчэнлин хийд нь Халх Монголын бурханы шашны гол сургалтын төв болж чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Хийдийн таван дацанд¹ бурханы шашны олон мэдлэг ухаанд лам хуврагууд суралцаж байв. Цанид² буюу гүн ухааны Дашчойнпэл, Гунгаачойлин, Идгаачойнзинлин дацангууд нь Төвдийн Гоман, Бэрэйвэн, Сэра хийдүүдийн гол дацангуудын сургалтын гурван өөр хөтөлбөрөөр сургалт явуулж байжээ. Их Хүрээний Гандантэгчинлин хийд нь Дотоод Ази дахь гэлүгвийн шашны том төвүүдийн нэг болж хөгжсөн юм. XX зууны эхэн үед Их Хүрээний сүм хийдүүдэд нийтдээ 10,000 орчим лам хувраг нар шавилан суралцаж байсан ба энд Халх Монголын хамгийн эрдэмтэй, оройн дээд болсон лам нарыг бэлтгэж байсан юм.

Хошуудын сүм хийдээс Гандантэгчинлин хийдийн дацангуудад ирж суралцаж байв. Зиндаагаа дүүргэж, дом тавьж эрдмийн зэргээ авсны дараагаар зарим нь эндээ үлдэж үргэлжлүүлэн суралцах, багшлах, алба хаах зэрэг зам хөөдөг байсан бол ихэнхи нь төрөлх хошууны сүм хийддээ буцдаг байжээ. Их Хүрээний дацангуудын хошуудтай тогтоосон хүчтэй хэлхээ холбоо, өндөр түвшний сургалт, төвлөрсөн хуврагийн чуулган, нийт Халхыг хамарсан томоохон зан үйлүүд зэрэг нь Гандантэгчилэн хийдийг Халх Монголын бурханы шашны төв болгон хөгжүүлсэн байна. Нэр алдар нь Дотоод Ази даяар түгсэн эрдэм мэдлэгийн их уурхай Төвдийн Сэра, Бэрэйвэн, Гандан хэмээх гурван гол хөлгөн хийдэд суралцаж ирснийхээ дараа хүртэл Монгол лам нар заавал Их Хүрээний Гандантэгчинлэн хийдэд хэсэг хугацаанд суралцаж,

¹ Төвд. Dratsang-хуврагийн хүрээ буюу шашны сургууль.

² Төвд. Mtshan-nyid, Мо. цанид- 1. Билэг чанар буюу бурханы шашны гүн ухаан 2. Бурханы шашны гүн ухааны сургалт.

суудаг уламжлал тогтсон байв. Энэ нь Их Хүрээ хэрхэн Халхын бурханы шашны эрх бүхий төв болсон байсныг харуулж буй юм.

Төвлөрсөн сүм хийдийн тогтолцооны өргөжилт ба бүс нутгийн сүм хийдүүд

XIX зууны 20-80-аад оны хооронд байгуулагдсан сүм хийдүүд дөрөвдэхь бүлэг ангиллыг үүсгэж байгаа юм. Хожмын буюу XIX зуунд байгуулагдсан нэлээдгүй сүм хийдүүд богино хугацаанд олон лам хуврагуудтай томоохон сүм хийдүүд болж өргөжиж ирсэн онцлог харагддаг ба эдгээрийг миний бие бүс нутгийн сүм хийд хэмээн нэрлэхийг санал болгож буй юм. Учир нь тэдний үйл ажиллагаа нэгэн хошууны хил хязгаар дотор хязгаарлагдсан бус, тэдний дийлэнхи нь Улиастай, Их Хүрээ зэрэг томоохон төвүүдийн хоорондох гол зам, өртөө, худалдааны газруудын дагуу байрласан байна. Тэдгээрийн нэг Ханд Чин Вангийн хүрээ нь 1867 онд байгуулагдсан хэдий ч 1890 онд 800 орчим, 1931 онд 1427 лам хуврагтай байв. Нарийн тогтолцоо бүтэц бүхий эдийн засгийн жасын тогтолцооноос гадна эдгээр сүм хийдүүд хошууны сүм хийдтэй олон талын харилцаа, хамтын ажиллагаатай байсан нь нэн сонирхолтой билээ. Хошууны сүм хийдтэй хамтарсан хурал, зан үйлийн үйл ажиллагааг явуулж байсан нь эдгээр бүс нутгийн сүм хийдийг хурдтай өсөхөд нөлөөлсөн байна. Тухайлбал тэд зуны хайлан, маанийн бүтээл зэрэг хурал зан үйлийг хамтран зохион байгуулж байсан байна.

Хошууны сүм хийд бүс нутгийн сүм хийдтэй хамтран ажилласнаар чухал, томоохон зан үйлийг хуврагийн чуулганы ачаар гүйцэлдүүлдэг байжээ. Бүс нутгийн сүм хийдийн өөр нэгэн онцлог үйл ажиллагаа бол олон хошууд, сүм хийдүүдийн лам хуврагуудыг хүлээн авдаг байсан явдал юм. Бүс нутгийн хийд болох Яруугийн хүрээ нь “бадарчингуудын хүрээ” хэмээн хочлон нэрлэгддэг байжээ. Ихэнхи сүм хийдүүд өөр хошуу нутгийн лам хуврагийг шавилан суулгах боломжгүй

байсан бол Яруугийн хүрээ зөвшөөрдөг байсан байна. Мөн хутагт, хувилгаадын үйл ажиллагаа бүс нутгийн сүм хийдийн үүсэл, хөгжилд чухал нөлөө болсон байна. Ламын гэгээн, Зая Бандидын хүрээ зэрэг эхэн үеийн томоохон хутагт хувилгаадын сүм хийд нь мөн томоохон бүс нутгийн төвүүд болон хөгжсөн. Гэтэл хожим сүм хийдээ байгуулсан Нарбанчин, Наран хутагт нарын сүм хийдүүд томоохон төвүүд болон хөгжиж чадаагүй бөгөөд учир нь тэдгээр хутагтууд өөрсдөө олон хошуудад уригдан залагдах үйл ажиллагаа нь түлхүү хөгжиж хошууд хооронд харилцаа холбоог хөгжүүлж байв. Эдгээр “нүүдэлчин” хутагт хувилгаад хошууд хоорондын харилцаанд гүүр болж байв. Бүс нутгийн томоохон сүм хийдүүдийн үүсэл, хөгжил, Их Хүрээний Гандантэгчинлин хийдийн төвлөрсөн сургалт, Богдын Их шавийн сүм хийдийн хүчирхэгжлийн явцад Халх Монголд лам нарын тоо үлэмж өссөн байна.

XX зууны эхэн үед 700-1500 лам хуврагтай байсан сүм хийдүүдийн ихэнхи нь 1810-1880 байгуулагдсан байгааг дор үзүүлье.

Сүм хийд	Байгуулагдсан он	Лам хуврагийн тоо
Ханд Чин вангийн хүрээ	1867	1427
Яруугийн хүрээ	1867	824
Галуутын хүрээ	1855	763
Дэжээлэн хүрээ	1814	880
Өлзийт хүрээ	1808	1010

XIX зуунд 60 жилийн дотор олон лам хуврагтай томоохон сүм хийдүүд бий болсныг дээрх жагсаалтаас харж болж байна. Их Хүрээний сургалт өндөр түвшинд хүрч олон эрдэмтэй лам нарыг бэлтгэсэн нь Их Хүрээнээс гадна бүс нутгийн томоохон сүм хийд бий болох нөхцөл бүрдсэн хэмээн Дашчойнпэл дацангийн шунлайв Гантөмөр тайлбарлаж байна. Мөн нөгөө талаар бүс нутгийн энэхүү томоохон сүм хийдүүд байгуулагдаж орон нутаг дахь сургалт сайжирсан нь эргээд

Их хүрээний сургалтанд түлхэц өгч, сайнаар нөлөөлсөн гэж үздэг байна. Бүс нутгийн сүм хийдэд мөн л өндөр түвшинд бэлтгэгдсэн лам нар Их Хүрээний аль нэгэн дацанд шавилахад доод зиндаанаас суралцаж эхэлдэг байсан нь тухайн зиндааны бусад лам хувраг нарыг улам илүү сурах, өрсөлдөх нөхцлийг бүрдүүлдэг байжээ.

Сүм хийдийн засаг захиргаа, эдийн засгийн зохион байгуулалт

XVIII-XIX зууны сүм хийдийн материалаас үзэхэд Халх Монголын сүм хийдэд засаг захиргааны гурван төрлийн тогтолцоо байжээ.

1. Богд Жавзандамбын Их шавийн харьяатууд отгуудад хуваагдан зохион байгуулагдаж байсан ба отог нь Манж Чин улсын засаг захиргаанаас өмнөх Монголчуудын аймаг доторх нэгж зохион байгуулалт байв. Отгийн зохион байгуулалтын онцлог нь нэг ураг төрлийн хүмүүсийн харьяаллыг илүүтэй хадгалдаг боловч Их шавьд хадгалагдан хэрэглэгдэхдээ энэ шинжээ алдсан ч анхны шавь, язгуурын хүмүүс гэсэн утгыг тээж байв.
2. Хоёрдахь нь тамгатай хутагт нарын шавийн зохион байгуулалт буюу дацангийн тогтолцоо байсан байна. Мөн ураг төрлийн харьяаллыг хамаарахгүй, аливаа хурал, зан үйлийг залгуулах ажил үүргээрээ хуваарилагдсан байдаг ба Ламын гэгээний шавь нар энэхүү дацангийн зохион байгуулалттай байв.
3. Их Хүрээний дацан сүм хийдийн лам нарыг зохион байгуулах аймгийн тогтолцоо ба энэ нь хошуудын харьяаллаараа 30 аймагт хуваагддаг байв.

Эдгээрээс тамгатай хутагтын сүм хийдийн зохион байгуулалтыг нарийвчлан авч үзье. Ламын гэгээний сүм хийдийн дансанд дурдархивын баримтанд “Тэнгэрийн тэтгэсний 43 (1778) онд Эрдэнэ бандид хутагтын хийдэд цогчин, лавиран, нүвлин, шарлин, гүшиг, диваажин, мамба,

чойр эдгээр 8 дуган барьж дацан хурал зохиож”¹ хэмээн дурдсан нь энэ шавийн хүрээний засаг захиргааны зохион байгуулалт нь их шавьтай адил отгуудад хуваагддаг бус харин дацангийн зохион байгуулалттай байсныг харуулна.

Мөн Бүрэнт Засагчийн 2-р оноос Бадруулалт Төрийн 3-р он хүртэл хөтлөгдсөн “*Гадагш зээлэнд өгсөн юмыг тэмдэглэж байх данс*”²-нд хэд хэдэн дацан, сан, жасаа, погууд дурдагдаж байна. Үүнээс үзэхэд Эрдэнэ бандид хутагтын хүрээний шавийн засаг захиргааны зохион байгуулалт нь зөвхөн дацангуудад хуваагдах төдийгөөр хязгаарлагдаагүй бололтой. Учир нь Төр гэрэлтийн сүүлийн жилүүдийн данснуудад мал хариулагчдын нэрийн өмнө төвд үсгээр Га, Ха, Жа, Дүй, Ла-ийн тэр гэж бичсэн байна. Эдгээр нь дацан ба жасуудын нэрсийг товчлон тэмдэглэсэн байх боломжтой бөгөөд Ша, Ши, Шо, Гэ (Хэ), Бу, Гү (Хү), О, Хор, Со, Ни, Үл, Жу, Ха (Га, төвд), Да (төвд), До, Дүй (төвд) гэсэн 16 товчлол байна. Тус шавьд дацан, сан, жас, жасаа, пог гэсэн 5 төрлийн хувиарлалт, зохион байгуулалт байжээ.

Харин Их Хүрээний Гандантэгчинлин хийдийн дацангуудад шавилан суугчид өөр засаг захиргааны тогтолцоотой ба 7-30 хүртлээ нэмэгдэж байгуулагдсан аймгуудад хуваагдан захирагдаж байв. Аймгийн тогтолцоо нь дацангуудад суралцах лам хувраг нарын суралцах нөхцлийг хангах тухайлбал, багш сонгох, хандив, өглөгийг хүлээн авахтай холбогдож хошууд, аймгуудын хатуу тогтсон харилцаан дээр тогтсон зохион байгуулалт юм. Аймаг бүр тогтсон харилцаатай хошуунаас лам хувраг нарыг хүлээн авах ба хэрвээ тогтсон аймагтаа очилгүй өөр аймагт харьяалагдсан байвал заавал буцааж авдаг нарийн журамтай байжээ. Жэймс Миллер “*Сүм хийд доторх лам хуврагуудын байр суурь нь тэдний орон нутгийн гээгийтэн нартай харилцах харилцаан дээр суурилж байв*”³ хэмээн дүгнэсэн байна.

¹ УТА, М-76, Д-1, хн-8

² УТА, М-76, Д-1, хн-15

³ Миллер 1962: 427-438.

Дээр цухас дурдсанаар жас нь Төвд, Монголын бурханы шашны сүм хийдийн эдийн засгийн байгууллага бөгөөд хурал, зан үйлийн үйл ажиллагааг гүйцэтгэхэд зарцуулагдах хөрөнгө, зардлыг хариуцаж байдаг. Жас нь *sru-i-sa* буюу “нийтийн газар, нийтийн хөрөнгө” хэмээх Төвд үгээс гаралтай⁴ юм. 1656 онд Их хүрээнд анхны жас байгуулагдсан мэдээ байна⁵. Жас нь хурал номын хэрэгсэл, зардал, лам хуврагийн манз цавийг залгуулах үүрэгтэйгээр анх байгуулагдаж улмаар өргөл, барьц хандиваар цугларсан мал, эд хөрөнгийг хадгалах, үржүүлэх аж ахуй болон зохион байгуулагдсан байна. Жасын гол хөрөнгө болох мал сүрэг нь эхэн үедээ өглөгийн эздийн гар дээр хэвээр адгуулагдаж байгаад улмаар түрээсээр хариулгах хэлбэрт шилжсэн. Дацан сүм бүр өөрийн жастай байхаас гадна тогтмол ба тогтмол бус, цаг цагийн хурлын жасууд байдаг. Ихэнхи нь хариуцсан хурлынхаа нэрээр Манла жас, Хайлан жас, Молом жас, мөн харьяалах дацангийн нэрээр Цанид, Дүйнхор, Жүдийн жас⁶ гэж нэрлэгддэг.

Монголын нүүдэлчдийн ахуй нь бэлчээрийн мал аж ахуй дээр суурилсан байгаль цаг уураас хараат нөхцөлтэй. Энэхүү өндөр эрсдэлтэй аж ахуйн нөхцөлд бурханы шашны хурал, номын үйл ажиллагаа нь тогтмол тасралтгүй байх шаардлагатай буюу хөрөнгө баялгийн хуримтлалыг шаардах болсон. Энэхүү эрсдлийг сүм хийд даван туулах шаардлагатай байсан ба энэ нь сан, жасын тогтолцоо байсан юм.

Сүм хийдийн мал сүрэг, өргөл хандивын эд зүйлсийн хуримтлал нь сангийн үүсэл болсон нь илэрхий. Сан нь хутагт, хувилгааны амины аж ахуй байсан⁷ гэж судлаачид үздэг. Богд Жибзундамба нь дотоод, гадаад сантай байсан ба

⁴ Сумаги Радна 1959

⁵ Өндөр гэгээний намтар

⁶ МУА, М-89, Д-1, ХН-6

⁷ Пүрэвжав.С 1978: 58

Дилав хутагт дотоод хэмээх хутагтын хувийн сантай байсан тухайгаа өгүүлсэн¹. Мөн зарим судлаачид сан нь сүм хийдийн дээд лам нарын мал сүрэг, хөрөнгө гэж үзсэн байна.

Сан, жасын талаар Миллэр нэн сонирхолтой санал дэвшүүлсэн юм. Түүний үзэж буйгаар нийт сүм хийдийн эдийн засаг нь хагас бие даасан сан, жасуудаас бүрдэх нэгдэл (corporation) байдлаар зохион байгуулагдсан² ажээ. Өөрөөр хэлбэл жасууд бие биенээсээ хамааралгүй үйл ажиллагаа явуулдаг буюу сан, жасын нярав нь эдийн засгийн үйл ажиллагааг бие даан явуулах эрхтэй байжээ. Жасын нярав жасаас зарах, худалдах, жин хөсөг хөдөлгөх эрхтэйгээс гадна ямар өрх айлаар малаа хариулгах шийдвэр гаргах зэрэг эдийн засгийн гол шийдвэрүүдийг гаргаж байжээ.

Гэхдээ сан нь жасаас салангид тусдаа оршоогүй харин ган зуд зэрэг эдийн засгийн эрсдлийн үед жасыг дэмжин түүний тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй болон хөгжсөн байна. Жас нь өөрийн харьяат шавь наргүй байсан бол сан мал сүргээ хариулгах харьяат шавьтай байв. Тиймээс сан нь засаг захиргааны зохион байгуулалтын нэгж болдог, жас зөвхөн эдийн засгийн үйл ажиллагааны нэгж байжээ. Эдийн засгийн хувьд сан жас 2 нь бие биенээ нөхсөн шинжтэй, жас ядууран доройтох үед сангаасаа дэмжлэг авах харилцаатай байжээ. Үүний хариуд жасууд санд тодорхой хувийн ашиг, шимтгэл өгдөг байсан бололтой.

Ш. Нацагдорж³ Богдын дотоод сан нь өглөг хандивын, гадаад сан нь мал түрээслэх, мөнгө хүүлэх зэрэг хөрөнгийг үржүүлэх эдийн засгийн үйл ажиллагаа явуулдаг байсан гэж үзсэн. Ламын гэгээний гадаад сан нь Их шавьтай адил Бадрах сан гэж нэртэй байна.

Миллэр “жасууд хэдийгээр бие даасан байдалтай үйл

¹ Дилав хутагт Б. Жамсранжав 2000

² Миллер 1959

³ Ш.Нацагдорж 1961.

ажиллагаа явуулдаг ч хийдийн ерөнхий захиргаа цогчинд захирагдаж түүний өмнө хариуцлага хүлээнэ. Жасууд төв цогчин жасын нэг хэсэг, цогчин жас нь зохион байгуулах төв болдог бөгөөд мөн бүх лам хувраг нарыг хариуцдаг. Бүх сан жасууд төв цогчин жасад дэмжлэг үзүүлж мөн өөрсдөө шаардлагатай үедээ дэмжлэг туслалцаа авдаг”⁴ гэж үзсэн.

Ламын гэгээний Цогчин жасын тусгай данс⁵ хадгалагдаж ирсэн ба тус дансанд гол төлөв хурал, тахилын хэрэглэл зардалд цогчин жасаас гаргах зүйлс ба мөн бусад дацан, жасуудаас ямар хэрэглэл нийлүүлэх, аль дацан хэдийд ээлжтэй болох зэргийг тэмдэглэжээ. Цогчин жасаас цогчин гонхны жасаа Данрагийн тахил, Намсрайгийн яамны тахил балин, Цэдэрийн зэд, Манла хурлын манз, Лавран хурим, Шүтээний зулын тахил, 4 зүгийн Цэсэм хурах, Танжид хурах, Ойдовын тахил балин, жасаа Чоймпормолом, Их Зуугийн Равнай, дооромбо нарын дамжааны манз зэрэг хурал, тахил, манз, зэдийг бүрэн даах ба хэсэглэн гаргаж байсан байна.

“Мөн өдөр Танжид хурахад сантай хамсаж дагахад эндээс 25 цай, 2 уналга түлээ, 2 домбо сүү, бага тос, 1 шанага давс. Мөн шөнө Нинса зэдийн чамарт 1 дундаж таваг гурил, бага тос 1 домбо манз, 1 дэн, мөн сэтрийн унаганд 1 дотордаш, өнгийн 4 ам самбай зүүвэй”⁶ гэснээс үзэхэд мөн хийдийн сантай хамтарч байна.

Цогчин жасаас өөрийн даалтыг бусад дацангуудад хуваан дамжуулах тохиолдол байсан нь “...энэ жасын чинээ мөхөс болсон учирт энэ жасаагийн урьдын гаргадаг 1 лан, 1 цэнгийн бараа 1 дотор дашийг түүгээр дийлэн хасаж дацангуудад өгсөн” гэснээс харагдаж байна.

Зарим жижиг сүм хийдэд Цогчин жас байгаагүй ба түүний оронд сан эсвэл аль нэг томоохон жас нь бусад жасуудыг

⁴ УТА, I-76, Д-1, ХН-35

⁵ УТА, М-76, Д-1, ХН-35

⁶ Мөн тэнд

удирдах, зохион байгуулах үүргийг гүйцэтгэж байсан байна.

Сүм хийдийн тогтолцооны бэрхшээл ба лам нарын өсөлт

XVIII-XIX хошуу, бүс нутгийн олон зуун сүм хийдүүд байгуулагдсан нь лам нарын тоог эрс нэмэгдүүлсэн байна. Тухайн үеийн эрдэмтэй лам нар энэхүү өсөлт нь лам хувраг нарын сахилга бат, сахил санваараа сахихад сөргөөр нөлөөлж байгаа буюу Халх Монголын бурханы шашинд тулгарч буй нэгэн бэрхшээл, асуудал хэмээн үзэж шүүмжлэлтэй хандаж байсан байна.¹

Төвдөд 1409 онд Гандан хийд, улмаар Бэрээвэн, Сэра зэрэг гэлүгвийн гол гурван хийд дараалан байгуулагдсан ба XX зууны эхэн гэхэд зөвхөн нэг л 13000 орчим лам хуврагтай байсан байна. Чухамхүү хуврагийн чуулган нь Гэлүгвийн шашны амжилтын нэг, суурь үндсүүдийн нэг хэмээн үздэг ба Монголчуудын дунд “чуулганы дээр бурханы ухаан байна (Төвд.tshogs kyi steng nas rnam mkyen yod. Цогий дэнай намчэн ёд) хэмээх хэлц үг хэлэлцэгддэг байжээ.

Энэ нөхцөлд сүм хийдийн дүрэм (жаяг-jaуig) чухал ач холбогдолтой болж олноор зохиогдох болсон байна. Гэлүгвийн сургалтын хөтөлбөрийн дагуу винай буюу лам хувраг нарын сахил санваар, ёс зүйн сургаалыг сургалтын төгсгөл хэсэгт үздэг ажээ. Жорж Драйфус энэ нөхцөл байдлыг тодруулж “Лам хувраг нар энэ парадоксыг ажигласан байдаг. Нэгэн Монгол гэвш “сахил байхад винай үгүй, винай байхад сахил үгүй” хэмээн хэлсэн тухай дурджээ. Тэрээр “...Лам хувраг нар сүм хийдэд шавилан суугаад сурч, мэдэх эрмэлзлээр дүүрэн байдаг, харин сүм хийдийн дэг журмын тухай мэддэггүй. Энэ талаар шууд зааж суралгүй 10-15 жил болдог. Винайг судалж эхлэх үед тэдний оргилуун урам зориг, тэмүүлэл нь алга болсон харин яг яах ёстойг дагахад бэлэн

¹ Агваанхайдавын сүмбүм зохиол, Vботь

байдаг.”² хэмээн тайлбарлажээ.

Энэ нь ёс суртахуун нь онолоор сурч ойлгож болдоггүй, дүрэм журам нь ажиглалт, гүн ухааны дүн шинжилгээний үүднээс хийгддэггүй хэмээх хандлага бурханы шашинд байгааг илэрхийлж байна. Бурханы шашны танин мэдэхүйн онолд ёс суртахуун нь “нуугдмал” шууд туршлага, учир шалтгаанаар таньж үл болох бодит байдал хэмээн үздэг. Тиймээс лам нарын сахилга дэг журам нь винайн сургаалаар биш харин сүм хийдийн дүрэм, жаягаар зохицуулагдаж ирсэн байна. Сүм хийдийн жаяг нь товч, дэлгэрэнгүй олон янз байх ба сүм хийдийн үйл ажиллагаа, лам нарын үйлдэл, биеэ авч явах арга замыг маш нарийвчлан зааж өгсөн байдаг.³

Гандантэгчинлин хийдийн лам нарын сахил санваарыг сахиулахтай холбоотой нэгэн түүхээс бид тухайн үед асуудал хэрхэн тавигдаж байсныг ойлгож болох юм.

Говийн V Ноён хутагт Равжаа Дэмчиг бурханы хувилгаан хэмээгдэх V Богдод их сүсэгтэй байсан тул Их Хүрээнд ирж түүнд мөргөхийг хүссэн байна. IV Ноён хутагтаас хойш дахин дүр тодруулахыг Манжийн захиргаанаас хорьсон байв. Гандан хийдийн хамба лам Агваанхайдав түүнийг Их Хүрээнд ирэхийг зөвшөөрөхгүй байв. Гэвч V Равжаа хутагт Хүрээнд ирж V Богдод мөргөжээ. Энэ үед нэгэн дүдмо-мам⁴ гарч Их Хүрээний лам нарын сахил санваарыг муутгаж байжээ. Агваанхайдав тэрхүү мамыг дарахад Равжааг золигт гарган ашиглахаар шийдэж сор хаясан байна. Равжаа хутагт Хүрээнээс гарч Туул голыг гатлан цаад талын эрэг дээр гишгэх үед нь Агваанхайдав сороо хаяж Гэлүгвагийн хамгаалагч Дамдинчойжоо бурханы магтаалыг уншжээ. Дамдинчойжоо, лам

² Драйфус 2003: 115.

³ Лхам 2011.

⁴ Төв. Bdudmo-мам, эм шулмас

нарын сахил санваарыг хамгаалахын төлөө Равжаа золигт гаргаж буй Агваанхайдавын энэ үйлдлийг таашаагаагүй байна. Равжаа Туул голын нөгөө эрэг дээр ухаан балартан унасан байна. Түүнийг сэрэхэд нэгэн мам түүн рүү харан хөхөрч зогсчээ. Равжаа өөрийн тарнийн номын хүчээр тэр мамыг дарсан ба тэр цагаас хойш Гандангийн лам хувраг нарын сахил санваар ихэд дээшилсэн гэдэг.¹

Лам хувраг нарын ёс суртахууны тухай сургаал номлолыг сургалтын төгсгөлд үзэж судалдаг нь хувь бодгал хуврагийн өөрийн сонголт, шийдвэрт тулгуурласан тогтолцоо байсныг харуулж байна. Лам хувраг нар сахилаа сахих, үргэлжлүүлэн сурах, хар болох зэрэг чухал шийдвэрүүд гаргахыг сүм хийдийн зүгээс зохицуулдаг биш гагцхүү хуврагийн өөрийн сонголт, шийдвэр дээр тулгуурладаг эрх чөлөөт тогтолцоо үйлчилж байсан байна.

Позднеев Халх Монголд хийсэн өөрийн аялалынхаа явцад хошууны сүм хийд цөөн лам хуврагтай, байнга суудаггүй болохыг онцлон тэмдэглэсэн байдаг. Чухал зан үйл, хэрэг явдлын үеэр цуглаж эргэн гэргийтний амьдралаар амьдрах нь түгээмэл байсан байна. Ямар ч нөхцөлд хошуу, бүс нутгийн сүм хийд соёл, эдийн засаг, нийгмийн харилцааны томоохон төвүүд байсан. Сүм хийдийн зан үйл, ёслолд оролцсоноор хувь хүн, гэр бүл, коммунити шашны хувьд сэтгэл санаа, итгэл үнэмшил авахаас гадна нийгмийн харилцаанд идэвхитэй оролцох боломжийг олж авдаг байсан байна.

Ном зүй

Агваанхайдавын сүмбүм зохиол V боть: Ялгуусны их шашин эрдэнэ бээр ялгуусан хөвүүн сэлтэд өргөсөн захидал бичиг

¹ Арга билиг сонин 1994 он.

тэргүүтний зүйлүүд оршвой.

Банзрагч 2007: *Монголын хүрээ хийдийн түүх (Өргөх цэсийн эмхэтгэл)*. Улаанбаатар

Кристофер Этвуд 2004: Монгол ба Монголын эзэнт гүрний нэвтэрхий толь (Christopher P. Atwood 2004: *Encyclopedia of Mongolia and Mongol Empire*. NY: Facts on File, Inc.)

Дилав хутагт Жамсранжав 2000: Ар Монголын Нарбанчин хийд. Ариун сэтгэл аварлын үндэс номонд, Улаанбаатар.

Ёохан Элвэрског 2009: Манай агуу их Чин: Хожуу Хятадын эзэнт улсын Монголчууд, бурханы шашин, төр (Johan Elverskog. 2009. *Our Great Qing: The Mongols, Buddhism and the State in Late Imperial China*. Honolulu: University of Hawai'i Press)

Жорж Драйфус 2003: Алга хавсархын дуун (Georges G. D. Dreyfus 2003: *The Sound of Two Hands Clapping*. A Phillip E. Lilienthal Book in Asian Studies.)

Лопез Доналд 2007: Төвдийн бурханы шашин (Lopez S. Donald. 2007. *Tibetan Buddhism* NJ: Princeton University Press.)

Миллер Жеймс 1959: Өвөр Монголын сүм хийд ба соёлын өөрчлөлт (Miller James Robert. 1959. *Monasteries and Culture Change in Inner Mongolia*. Wiesbaden: Otto Harrassowitz.)

Миллер Жеймс 1962: Бурханы шашны сүм хийдийн эдийн засаг: Жасын механизм (Miller James Robert, “*Buddhist Monastic Economy: The Jisa Mechanism*”, The Journal of Asian Studies, 1962, Vol. 3, pp.427-438.)

Ш. Нацагдорж 1972: Сум, хамжлага, шавь ард. Улаанбаатар.

С. Пүрэвжав 1978: Монгол дахь шарын шашны хураангуй түүх. Улаанбаатар.

Сумати Радна 1959: Нэр, үг, утга гурвыг сайтар тодруулагч толь. Улаанбаатар

МҮА (Монголын Үндэсний архив) М-89, Д-1, ХН-8

МҮА, М-76, Д-1, ХН-15

ҮТА, М-76, Д-1, ХН-35

МҮА, М-89, Д-1, ХИ-6, Шүтээний аймгийн цанид дацангийн гадагш зарсан юмсын данс

Өргөх цэс:7695. Улсын төв номын сан, гар бичмэлийн сан.

Эрдэнэ зуу хийд ба Өндөр гэгээний намтар: УТНС, гар бичмэлийн сан